# ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 05 өдөр Дугаар А/13 Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Нийслэлийн Засаг даргын 2015 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн А/11 тоот тушаал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2015 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 03/644 тоот албан мэдэгдэл, Байгууллагын дүрмийн 5.1.8, Байгууллагын удирдлагын багийн 2015 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн хурлын 03 тоот шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажлын байрны засварын ажлыг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Ажлын хээсгийн ахлагч | Барилга, байгууламжийн инженер |
| Гишүүд | Эдийн засагч |
| | Хуулийн зөвлөх |

2. Нийслэлийн Засаг Захиргааны 4 дүгээр байрны 5 дугаар давхарын 2 өрөөг 4 өрөө болгон хана хийж засварлах иргэн, байгууллагатай гэрээ байгуулан засварын ажлыг 3 дугаар сарын 13-ны дотор гүйцэтгүүлсүгэй.
3. Ажлын байрны өрөө тасалгааны байршлыг оновчтой зохион байгуулж засварын зардлыг өнөөгийн бодит үнэ ханшаар тооцон гаргахыг Барилгын инженер /Г.Пүрэвдорж/-д даалгасугай.
4. Шилжүүлэн байршуулах ажлын байрны засварын ажлын гүйцэтгэлийн 8,261,000 /найман сая хоёр зуун жаран нэгэн мянга/ төгрөгийн төлбөрийг батлагдсан төсвийн бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч /Г.Батням/-д зөвшөөрсүгэй.
5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагааны албаны дарга /Л.Мөнхтуяа/-д даалгасугай.

УЛААНБААТАР ХОТ
ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ

ДАРГА М.ГОНЧИГЖАВ

3150600024